



**САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2026/08/НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2026 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn Аудитын менежер: П.Хорлоосүрэн Утас: 70323833 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.20 № 148

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Э.ГОНЧИГ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Өлзийт сумын Төрийн сангийн санхүүгийн тайлангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Өлзийт сумын Төрийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өлзийт сумын Засаг даргын тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 491.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд Засаг даргын тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн ерөнхий орлогын санхүүгийн тайлангууд, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг байгууллагуудын тогтмол зардал, урсгал засварын зардлын тайлангууд нэгтгэгдсэн байна. Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 1,583.4 сая төгрөгийн хөрөнгө, 1,710.6 сая төгрөгийн орлого, 1,751.6 сая төгрөгийн зардал нэгтгэгджээ.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

6225020328

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

### Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		675,933.13	508,469.66
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	426,752.15	324,883.67
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	247,093.08	181,498.09
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,087.9	2,087.9
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,039,302.16	1,074,889.67
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,039,302.16	1,074,889.67
7	1.2.2.02 Биет хөрөнгө		1,029,904.49	894,418.6
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	9,397.67	180,471.07
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,715,235.29	1,583,359.33
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,106.45	83,065.65
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		5,106.45	83,065.65
12	2.1.1.03 Өглөг		5,106.45	83,065.65
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,710,128.84	1,500,293.68
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		1,710,128.84	1,500,293.68
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		492,715.21	492,715.21
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		1,094,800.03	884,964.87
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		122,613.6	122,613.6
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,715,235.29	1,583,359.33

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		1,920,188.39	1,710,616.35
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		399,647.15	490,438.37
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		385,314.47	386,737.67
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		416,494.82	419,514.2
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-31,180.35	-32,776.52
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		8,824.67	8,992.45
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		5,508	94,708.24
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	346,505.09	1,220,177.99
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	984,375.07
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,174,036.15	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,747,224.96	1,751,641.26
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,747,224.96	1,751,641.26
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,706,146.66	1,719,925.96

**Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		730,125.24	843,629.85
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		89,946.25	105,261.62
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		356,840.12	358,700.49
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		35,256.6	40,934.78
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал		580.4	0.0
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		45,440	79,672.8
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		11,544	16,538
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		39,385.09	20,973.64
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		397,028.97	254,214.79
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		41,078.29	31,715.3
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		172,963.43	-41,024.91
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		110,215	168,810.25
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-110,215	-168,810.25
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		62,748.43	-209,835.16

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,655,051.73		1,655,051.73
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,671.32		-7,671.32
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,647,380.4		1,647,380.4
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	62,748.43		62,748.43
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,710,128.84		1,710,128.84
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,710,128.84		1,710,128.84
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,710,128.84		1,710,128.84
8	1.7 Тайлант үеийн үр дүн	-209,835.16		-209,835.16
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,500,293.68		1,500,293.68

**2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан**

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,758,875.03	1,764,105.22
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	399,647.15	490,438.37
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	385,314.47	386,737.67
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-31,180.35	-32,776.52
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	8,824.67	8,992.45

**Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	5,508	94,708.24
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,349.6	7,462.4
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	3,088.4	3,595.84
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	83,520
10	1.1.1.1.03.8.04 Бусад татвар	70	130
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	185,191.73	1,273,666.85
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	185,191.73	168,765.28
13	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	984,375.07
14	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	120,526.5
15	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,174,036.15	0.0
16	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,494,384.15	1,537,518.17
17	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,494,384.15	1,537,518.17
18	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,453,305.85	1,505,802.87
19	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	725,484.91	848,270.18
20	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,946.25	105,261.62
21	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	356,840.12	355,514.25
22	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	31,169.47	28,255.75
23	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	580.4	0.0
24	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	45,440	79,672.8
25	1.1.1.2.01.1.07 Төмилөлт, зочны зардал	10,293	16,538
26	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	129,460.22	31,969.76
27	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	64,091.49	40,320.52
28	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,078.29	31,715.3
29	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	264,490.88	226,587.05
30	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	129,246.9	327,500.28
31	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	129,246.9	327,500.28
32	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	129,246.9	327,500.28
33	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-129,246.9	-327,500.28
34	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150	955.25
35	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-150	-955.25
36	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	135,093.98	-101,868.48
37	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	291,658.17	426,752.15
38	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	426,752.15	324,883.67

Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

д/д	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,828,209.90	1,764,516.64
2	3.1.01.1.1 Татварын орлого	467,469.60	490,438.37
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	363,469.20	386,737.68
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	396,245.70	419,514.20
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	312,700.00	337,725.44
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	52,741.20	41,926.82
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	29,584.50	38,511.94
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,220.00	1,350.00
9	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-32,776.50	-32,776.52
10	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-32,776.50	-32,776.52
11	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	7,654.10	8,992.45
12	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	6,929.30	7,912.45
13	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	724.8	1,080.00
14	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	96,346.30	94,708.24
15	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,376.30	7,462.40
16	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	5,620.00	5,558.20
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,756.30	1,904.20
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	4,250.00	3,595.84
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	4,250.00	3,595.83
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	83,520.00	83,520.00
21	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	83,520.00	83,520.00
22	3.1.01.1.1.8.4 Бусад татвар	200	130
23	3.1.01.1.1.8.4.03 Нохойны албан татвар	200	130
24	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,360,740.30	1,274,078.27
25	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	165,675.60	171,754.37
26	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	18,600.00	19,104.50
27	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	146,475.60	149,220.78
28	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	600	440
29	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	-	2,989.09
30	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,074,538.20	981,797.40
31	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,074,538.20	981,797.40
32	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	-	-
33	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	120,526.50	120,526.50
34	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	120,526.50	120,526.50
35	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,257,233.30	1,863,396.01
36	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,717,173.20	1,546,619.48
37	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,683,462.40	1,514,904.18
38	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	908,091.00	848,270.17

**Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

39	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	407,758.80	395,024.59
40	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	424,350.90	387,511.11
41	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	27,984.00	22,627.93
42	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	47,997.30	43,106.53
43	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,511.50	105,261.61
44	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	77,187.80	71,740.18
45	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	9,081.00	8,334.97
46	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	4,540.40	4,185.34
47	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	4,540.40	4,185.34
48	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	18,161.90	16,815.79
49	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,159.20	355,514.25
50	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	34,152.30	36,103.17
51	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	334,538.50	315,523.38
52	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	8,468.40	3,887.70
53	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	43,589.80	26,442.96
54	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	6,999.80	2,284.40
55	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	27,500.00	18,225.99
56	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,950.00	4,640.57
57	3.1.01.2.1.1.4.04	Ном, хэвлэл	250	42
58	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,890.00	1,250.00
59	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	300	-
60	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300	-
61	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	109,175.20	91,351.80
62	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	7,922.90	7,179.00
63	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	101,252.30	84,172.80
64	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	21,300.00	16,538.00
65	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	21,300.00	16,538.00
66	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,531.00	31,204.87
67	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,025.00	30,285.67
68	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	594	594
69	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	220	220
70	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	84	56.2
71	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250	49
72	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	358	-
73	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	72,804.70	40,320.52
74	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	65,804.70	36,882.92
75	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000.00	3,437.60
76	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,710.80	31,715.30
77	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	
78	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	
79	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	33,710.80	31,715.30

**Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

80	3.1.01.2.1.4.2.06 ТЭТГЭМЖ	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,845.10	30,845.10
81	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,865.70	870.2
82	3.1.01.2.2	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	369,402.60	315,821.28
84	3.1.01.2.3 ЦЭВЭР ЗЭЭЛ	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН</b>	170,657.50	955.25
85	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	170,657.50	955.25
86	3.1.01	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-429,023.40	-243,623.58
88	3.1	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-429,023.40	243,623.58
90	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-429,023.40	243,623.58
92	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	426,752.15
93	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	324,883.67
94	6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	48	48
95	6.1	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	2	2
96	6.1.01	Төсвийн байгууллага	2	2
97	6.2	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	23	23
98	6.2.01	Удирдах ажилтан	8	8
99	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	13	13
100	6.2.03	Үйлчлэх ажилтан	2	2
101	6.5	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	23	23
102	6.5.01	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
103	6.5.09	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
104	6.5.11	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

д/д	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 <b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	2,577.67
2	1.1.1.1.1 <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	2,577.67
3	1.1.1.1.1.1 <b>Тусламжийн орлого</b>	2,577.67
4	1.1.1.1.1.1.1 <b>Хандив тусламж /дотоод/</b>	2,577.67
5	1.1.1.1.1.1.1.1 <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,577.67
6	1.1.1.1.1.1.1.1.4 <b>Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө</b>	2,577.67
7	1.1.1.2 <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,577.67
8	1.1.1.2.1 <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,577.67
9	1.1.1.2.1.1 <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,577.67
10	1.1.1.2.1.1.4 <b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,812.78
11	1.1.1.2.1.1.4.2 <b>Тээвэр, шатахуун</b>	1,572.78
12	1.1.1.2.1.1.4.3 <b>Шуудан, холбоо, интернэтийн төлбөр</b>	240.00
13	1.1.1.2.1.1.8 <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	764.89
14	1.1.1.2.1.1.8.1 <b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	764.89
15	1.1.1 <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	0.00
16	1.1 <b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	(0.00)
17	1 <b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	(0.00)

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### **3.1 Төлбөрийн акт**

Тус байгууллага дээр акт гараагүй.

### **3.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй.

### **3.3 Зөвлөмж**

Зөвлөмж өгөөгүй.

### **3.4 ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил**

Сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС зэрэг орон нутгийн 4 байгууллага түүвэрт хамрагдсан.

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр **1,135.1** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 898.8 сая төгрөгийн 8 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлсэн. Аудитын явцад 236.3 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

#### **Сумын ЗДТГ-т 541.1 сая төгрөгийн дараах алдаа, зөрчил илэрсэн.**

-ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 45.0 сая төгрөгийн 3 худаг, 173.8 сая төгрөгийн авто замын зураг төсөв, ОНХО-аар нийлүүлэгдсэн 11.6 сая төгрөгийн 4 мотоцикл нийт 230.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, Нийлүүлэгч компанид дутуу шилжүүлсэн халаалтын зардал 3.2 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байсан алдааг залруулсан.

-Албан томилолтоор ажилласан хугацаанд 12 албан хаагчид 534.8 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон, жилийн эцсээр 188.5 сая төгрөгийн барилга байгууламж, 51.4 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж, 36.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 24.2 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, нийт 300.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2.1 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас эрдэм шинжилгээний хурлын илтгэгчдэд 1.0 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл өгсөн, мөн ЕБС-ийн дотуур байрны засварт 3.2 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлсэн зэрэг 307.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

-Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш орлогын 18, зарлагын 12 гүйлгээг хугацаа хоцроосон, өмч хөрөнгө зарцуулсан 19 шийдвэрийг хугацаа хоцроосон, шатахуун, сэлбэг хэрэгсэл, засварын материал, бичиг хэрэг гэх мэт бараа материалын тайланг сар бүр тогтмол гаргаагүй, хуримтлуулж байгаад нэг бөөн байдлаар тайланд тусгадаг, орлого зарлагын анхан шатны баримтын бүрдүүлэлт эмх замбараагүй шаардах хуудас хөтлөөгүй зэрэг зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн.

#### **Сумын ИТХ-д 48.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн.**

- Санхүүгийн тайланд шатахуун нийлүүлэгчтэй холбоотой өр төлбөрийг 2.7 сая төгрөгөөр илүү тооцож тусгасан байсныг залруулсан.

- Жилийн эцсээр 30.0 сая төгрөгийн авто машин, 3.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж, 6.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 39.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, бараа үйлчилгээний бусад зардлаас /төлөөлөгчдийн зардал/ 1.8 сая төгрөгийг эрдэм шинжилгээний хуралд оролцох арга хэмжээнд зарцуулсан

- Урсгал засварын зардлаас 4.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдаж авсан зэрэг 45.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

- Шилэн дансны цахим хуудаст дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, байгууллагын батлагдсан төсөв, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга

хэмжээний тайлан, таван сая төгрөгөөс дээш орлогын 13 гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулсан 10 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

### Сумын ОНХС-д 545.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан нийт 138.7 сая төгрөгийн газар тариалангийн иж бүрэн тоног төхөөрөмж 3 үрлэгч, 1 трактор, 1 анжсыг үндсэн хөрөнгийн орлогод аваагүй, сумын 1 дүгээр багийн дээд улаан хад, 3 дугаар багийн ягаан толгой, 4 дүгээр багийн эхэн цагаанд худгийн цооног гаргах ажлын үнэлгээний хорооны гишүүдийн санал зөрүүтэй байхад шийдвэр гарган, гэрээ байгуулсан, Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 283.1 сая төгрөгийн 13 зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 78.8 сая төгрөгийн 9 гүйлгээ, 169.1 сая төгрөгийн 6 хөрөнгө зарцуулах шийдвэрийг байршуулаагүй зэрэг 545.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-г хөрөнгийн бүртгэлд тусгахдаа журам зөрчин сумын Засаг даргын 2025 оны 12 дүгээр сарын 24-ний өдрийн А/83 дугаар “Хөрөнгө бүртгэлд авах тухай” захирамжаар шийдвэрлэж, ИТХ-ын тогтоол гаргаагүй байна. Хөрөнгийг актаар хүлээн авсан хугацаа болон хөрөнгө орлогод авах шийдвэр гарсан огноо зөрүүтэйгээс шалтгаалан бүртгэлд тусгахдаа харилцан адилгүй хугацаагаар хөрөнгөө орлогод бүртгэсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Сумын Засаг даргын тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 491.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй тул Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн	00	00	00	0	00	0	00	00	00	00	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	1	00	0	00	00	00	0	00	1	2	0	0

Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн	0	0 0	0 0	0 0	0 0	0	0 0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	0	0 0	0 0	0 0	0 0	0 0	0	0	0
Нийт дүн	0 0	0 0	0 00	0 0	0 0	0	0 0	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НЫ ӨДӨР